



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/546

Есөнбулаг

Эрхийн гэрчилгээний хугацаа  
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд эзэмшил газрын эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн Бадарчийн Сарангэрэл (ШЖ66042461)-ийн 8208001752 нэгж талбарт эзэмшиж байгаа газрын эрхийн гэрчилгээний хугацааг 5 жилээр сунган эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3. Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

